



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 15

Мандалговь

Г

С.Хуланг албан тушаалд

Т

нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 4 дүгээр хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Сандагийн Хулан 98.2 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа С.Хулангийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

180021029